


БАТЛАВ  
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 ДАРГА Д.ОЮУНЦЭЦЭГ

2016 он 01 сар 21 өдөр



**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр

Багануур дүүрэг

**ЗОРИЛГО:**

*Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангахад оршино.*

Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт					Хүрэх үр дүн
д/д	Хийх ажлын агуулга	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	Хариуцах эзэн	
1	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх <b>Эрх зүйн үндэслэл:</b> • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2;	1.1 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2 сарын 5-ны дотор	ААНБ-ын удирдлагууд	Тайлан, мэдээ хуулийн хугацаанд үнэн зөв гарч хүргэгдсэн байна.
		1.2 Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх	жилдээ		
		1.3 Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд АТГ болон холбогдох байгууллагад хүргүүлсэн байх	11 сарын 10-ны дотор		
		1.4 Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх			
		1.5 ХАСХОМ-ийн болон бусад тайлан, мэдээг хугацаанд нь нэгтгэж гаргах	01-р сарын 30-ны дотор	ЭБАТ	



2	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 9 дүгээр зүйлийн 9.1.2.</li> </ul>	2.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал, сургалт /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад болон иргэдэд/ г.м	Улирал бүр	ЗДТГ, АУССГОНЗөвлөл, ААНБ-ын удирдлагууд	ААНБ-уудаас Авлигын эсрэг хуулийн хүрээнд хийж буй ажил ил тод болно.
		2.2 ЗДТГ-ын “Авлигагүй Багануур” самбарын мэдээллийг шинэчлэх, мэдээ мэдээлэл байршуулах	Тухай бүр		Иргэд мэдээлэл авах боломжоор хангагдаж, мэдлэг боловсрол дээшилнэ.
		2.3 Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад тараах			
		2.4 Авлигатай тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, дүүргийн ИТХ, Засаг даргаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах			
3	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3</li> </ul>	3.1.Нутгийн захиргааны байгууллагуудад Авлигын эсрэг хууль хэрхэн хэрэгжиж байгаад хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулсан байх	1-р улиралд	ЗДТГ, АУССГОНЗөвлөл	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт сайжирна.
		3.2. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх	2-р улиралд		
4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл,	4.1 Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны	Хугацаанд нь		



		авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх	улиралд		
4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл</li> </ul>	4.1 Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, сар, улирлын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/, хагас жилийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлан /8-р сарын 15-ны дотор/, дараа жилийн төсвийн төсөл /9-р сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсанд байршуулах	Хугацаанд нь	ААНБ-ын удирдлагууд болон холбогдох албан тушаалтнууд	Иргэд төсвийн талаархи мэдээ, мэдээллийг цахим хуудаснаас олж авах нөхцөл бүрдэнэ
		4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах	4-р сарын 25-ний дотор		
		4.3 Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах			
		4.4 Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	7 дугаар сарын 1-ний дотор		
		4.5 Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Улирал бүр		
		4.6 Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх	өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт		
		4.7 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ болон гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг цахим хуудсанд тогтмол байршуулах	7 хоногийн дотор		



		4.8 Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох <i>Татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл</i>	Сар бүр		
		4.9. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор		
		4.10. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Улирал тутам		Дүүрэгт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаархи мэдээлэл иргэдэд нээлттэй, ил тод болно.
5	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8</li> </ul>	5.1 Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл <i>Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл</i> -ийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулах. 5.2 Дээрх зөвшөөрөл <i>Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл</i> -ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд байршуулах 5.3 Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулах	1-р улиралд	Захирагчийн ажлын алба	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл <i>Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл</i> -ийн талаар иргэд мэдээлэлтэй болно.
6	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах <b>Эрх зүйн үндэслэл:</b>	6.1 Сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулах 6.2 Сонгон шалгаруулалт явагдах зарыг олон нийтийн хэвлэл	зарлагдсан тухай бүр	Дүүргийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ААНБ-ын	Хүний нөөцийн ил тод байдал



	<ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл</li> </ul>	<p>мэдээллийн хэрэгслээр зарлах</p> <p>6.3 Нийтийн албан тушаалд томилогдох иргэдээс ХАСУМ авч АТГ-аар хянуулсны дараа захирамж, тушаал гаргах</p>	Тухай бүр	удирдлагууд, ЭБАТ	хангагдана.
7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл</li> <li>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5</li> </ul>	<p>7.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах</p>	1-р сард	ХААА Н.Жаргалсайхан	Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх мэдээлэл иргэдэд нээлттэй болно.
<p>7.2 Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалт явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулсан байх</p>	ХААА , Үнэлгээний хорооны НБДарга нар				
<p>7.3 Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх</p>	ХААА Н.Жаргалсайхан				
<p>7.4 Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах</p>	Хагас бүтэн жилээр				
<p>7.5 Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх</p>	СТСХ Б.Уранжаргал				
<p>7.6 Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх</p>	Үнэлгээний хорооны НБДарга нар				
<p>7.7 Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах</p>	ХААА Н.Жаргалсайхан				
<p>7.8 Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн</p>	Дүүргийн Засаг дарга				



		хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх			
8	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6</li> </ul>	8.1 Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлсэн байх, АБТ-ыг цахим хуудсанд байршуулах 8.2 Хариуцсан ажил үүргийн чиглэлийн талаархи мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	2 сарын 10-ны дотор	ААНБ-уудын удирдлагууд	Ажилтан албан хаагчдын чиг үүрэг болон бусад мэдээлэл иргэдэд нээлттэй болно
9	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13;</li> <li>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3</li> </ul>	9.1 Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх <i>/сонгон шалгаруулалтаар /</i> 9.2 Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайланд тусгасан байх 9.3 Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлсэн байх	Тухай бүр	ЗХХ, АУССГОН-ийн зөвлөл, ААНБ-ын удирдлагууд	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллагаа сайжирна. Иргэдэд холбогдох мэдээ мэдээлэл нээлттэй хүрэх боломж бүрдэнэ
10	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл</li> </ul>	10.1 Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх 10.2 Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх	1-р улирал	ААНБ-ын удирдлагууд	Хуулийн хэрэгжилт хангагдана
11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн	11.1. Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн	1-р улиралд		



	<p>дүрмийг тогтоон мөрдүүлэх <b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;</li> <li>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6</li> </ul>	<p>саналыг тусгасан байх</p> <p>11.2. Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/</p> <p>11.3. Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх</p> <p>11.4. Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах</p> <p>11.5. Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх</p> <p>11.6. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх</p>	<p>2-р сард багтааж</p> <p>1-р улиралд</p> <p>жилдээ</p> <p>Улирал тутам</p>	<p>ААНБ-ын удирдлагууд</p>	<p>Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдана.</p>
<p>12</p>	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах <b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;</li> <li>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5</li> </ul>	<p>12.1. Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/</p> <p>12.2. Удирдлагаас гаргасан байгууллагын болон хувийн нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/ -ийг цахим хуудсанд байршуулах</p> <p>12.3. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>12.4. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсанд байршуулах /түрээс/</p>	<p>жилдээ</p> <p>тухай бүр</p> <p>1-р улиралд</p> <p>Улирал тутам</p>	<p>ААНБ-ын удирдлагууд</p>	<p>Удирдлагаас гаргасан шийдвэр иргэдэд нээлттэй болно</p>



13	<p>Иргэдийн өргөдөл, /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;</li> <li>• НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;</li> <li>• Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг</li> </ul>	<p>13.1. Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</p> <p>13.2. Иргэдийг хүлээн авч уулзах албан тушаалтны нэр, харилцах утас, цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулах</p> <p>13.3. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр улирал тутам мэдээлэх</p>	1-р улиралд	ААНБ-ын удирдлагууд болон холбогдох албан тушаалтнууд	Иргэд өргөдөл, гомдлоо гаргах, шийдвэрлэлтийн байдалтай танилцах боломж бүрдэнэ.
14	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p><b>Эрх зүйн үндэслэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1</li> </ul>	<p>14.1 Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах /жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх/</p> <p>14.2 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх <i>/хүнд суртал, чирээдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдээгдэл гаргах, албан</i></p>	1-р улиралд	ЗХХ, АУССГОНЗөвлөл, ААНБ-ын удирдлагууд	Авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.




		<i>хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/</i>			
15	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахгүй байх <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4;</li> <li>• НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1</li> </ul>	15.1 Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах	2-р сард	ЗДТГ, АУССГОНЗөвлөл	Хуулийн хэрэгжилт хангагдана.
16	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх <b>Эрх зүйн үндэслэл:</b> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2</li> </ul>	16.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмж, албан бичиг, дүрэм, журам, заавар, шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх 16.2 АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх	Жилдээ	ААНБ-ын удирдлагууд	Холбогдох байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилт хангагдана.
17	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх, манлайлах	17.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-ыг дэмжин, хамтарч ажиллах 17.2 Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах /Онол практикийн бага хурал, хэлэлцүүлгүүд/	Жилдээ  Эхний хагас жилд	ЗДТГ, АУССГОНЗөвлөл, ААНБ-ууд	ААНБ-ын удирдлагуудын Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нэмэгдэнэ.
18	Албан хаагчдын шударга байдал	18.1 Албан тушаалтан, албан	1-р		



ба түүнийг нэмэгдүүлэх	хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/ арга хэмжээ зохион байгуулах	улиралд	ААНБ-ын удирдлагууд	Төрийн албан хаагчдын Ёс зүй дээшилнэ.
	18.2 “Төрийн албан хаагчдын Ёс зүй”, “Удирдах ажилтны Ёс зүйн манлайлал” сэдэвт сургалтыг бусад байгууллагатай хамтран зохион байгуулах	2-р улиралд		

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРГАА , ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ТУЯА